



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/16С

Номгон

Сургалт зохион байгуулах зардал олгох  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах 6.1.3 дахь заалтын задаргааны 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Мэргэжлийн бүлгийн хөгжил-чадварлаг багш" бүсийн сургалтыг 2023 оны хичээлийн жилийн 02 дугаар улирлын амралтаар зохион байгуулсугай.


2.Сургалт үйл ажиллагааны зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалт арга хэмжээг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг)-т үүрэг болгосугай.

4.Сургалт арга хэмжээний зардал болох 5.255.860 (Таван сая хоёр зуун тавин таван мянга найман зуун жаран) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний "Чадварлаг багш" арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаад зөвшөөрсүгэй.

5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь), Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр) нарт даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310391

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 28 ны өрнийн 8/1/16 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

УДИРДАМЖ

2023 оны 03 дугаар сарын 28

Номгон

**“Мэргэжлийн бүлгийн хөгжил-чадварлаг багш”  
бүсчилсэн сургалт, үйл ажиллагаа зохион  
байгуулах тухай**

**Зорилго.** Мэргэжлийн бүлгийн үйл ажиллагаагаар багшийн хөгжлийг дэмжих, 1 дүгээр түвшинд үнэлэгдсэн багш нарын сайн туршлага арга зүйг түгээн дэлгэрүүлж хамтран хөгжих.

**Хугацаа.** 2023 оны 03 дугаар сарын 30-31-нд

**Хамрах хүрээ:** Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгүүд

**Үйл ажиллагаанд оролцогчид:** Захирал, эрхлэгч, арга зүйч, багш нар  
(Ерөнхий боловсролын сургуулиас 5, цэцэрлэгээс 2 оролцогч)

**Зохион байгуулах газар:**

1 дүгээр бүс: Баянговь суманд: Номундалай, Гэгээн сумади, Өлзийт, Жинст, Богд, Баянлиг, Баянговь сумын сургууль цэцэрлэг, 6, 7, 12, 15 дугаар цэцэрлэг

2 дугаар бүс: Заг суманд: Номгон, 5 дугаар сургууль, Баян-овоо, Галуут, Мандал, Жаргалант, Заг, Гурванбулаг сумын сургууль цэцэрлэг, 2, 9, 11 дүгээр цэцэрлэг

3 дугаар бүс: Хүрээмарал суманд суманд: Эрдэнэмандал, Соого сейко, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг сумын сургууль цэцэрлэг, 3, 4, 10 дугаар цэцэрлэг

4 дүгээр бүс: Баян-өндөр суманд: Эрдэм, Баян-ойт, Баацагаан, Баянцагаан, Баян-өндөр, Шинэжинст, Шаргалжуутын сургууль цэцэрлэг, 1, 5, 13, 14 дүгээр цэцэрлэг

**Үйл ажиллагаа.**

**1.Мэдээлэл.** Сургуулиуд дараах сэдэв тус бүрээр илтгэл танилцуулна.  
(Чиглүүлэгч: Боловсролын ерөнхий газар, Боловсрол шинжлэх ухааны газрын мэргэжилтнүүд)

## 2.

Мэргэжлийн Хөгжлийн бүлгийн үйл ажиллагаа, багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөлт, үр дүн. (20 минут)

Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд суурилсан багшийн хөгжлийн төлөвлөгөө. (20 минут)

Сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгаж байгаа сайн туршлага, арга зүй. (20 минут)

Байгууллагын үнэлгээнд анализ хийж сургуулийн менежментэд тусгасан байдал (20 минут)

**2.Хэлэлцүүлэг.** Багшийн болон байгууллагын үнэлгээний түвшинг ахиулах боломж нөхцөл. (Чиглүүлэгч: Боловсролын ерөнхий газар, Боловсрол шинжлэх ухааны газрын мэргэжилтнүүд)

**3. Сургалт.**

Багш нар мэргэжлийн хөгжлийн бүлгээр хөгжих нь.

Даалгаврын үр дүнд шинжилгээ хийх.

Цахим контент боловсруулах арга зүй. (Боловсрол шинжлэх ухааны газрын мэргэжилтнүүд)

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын 2013 оны 3 дугаар сарын 28 ны өдрийн 28/3 дугаар захирамжийн хөдөлгөөнөөр хавсралт



**“МЭРГЭЖЛИЙН БҮЛГИЙН ХӨГЖИЛ-ЧАДВАРЛАГ БАГШ”  
БҮСЧИЛСЭН СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ТӨСӨВ**

**А. Шатахууны зардал.**

|                 |                                      | Сум<br>хооронд<br>ирж<br>очих<br>зай | Зарцуулах<br>бензин | Бензиний<br>үнэ | Нийт           |
|-----------------|--------------------------------------|--------------------------------------|---------------------|-----------------|----------------|
| 1               | Баянхонгор-Баянговь-Баянхонгор       | 500                                  | 100                 | 2530            | 253000         |
| 2               | Баянхонгор-Баянцагаан-<br>Баянхонгор | 500                                  | 100                 | 2530            | 253000         |
| 3               | Баянхонгор-Хүрээмарал-<br>Баянхонгор | 450                                  | 90                  | 2530            | 227700         |
| 4               | Баянхонгор-Заг-Баянхонгор            | 360                                  | 72                  | 2530            | 182160         |
| <b>Нийт дүн</b> |                                      |                                      |                     |                 | <b>915.860</b> |

**Б. Сургалт зохион байгуулах үйл ажиллагааны зардал**

|                   | Зардал   | Төсвийн задаргаа   | Нийт             |
|-------------------|--|--|------------------|
| 1                 | Сайн арга зүйтэй багш нарын туршлагыг түгээн дэлгэрүүлэх | 10 багшийн туршлагыг тухайн байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгслээр /нэг багшид гарах зардал 150.000/ | 1.500.000        |
| 2                 | Байгалийн ухааны хичээлийн үзүүлэн бэлтгэх               | Физикийн хичээлээр лаборатори туршилт хийх гарын авлага, контент бэлтгэх                               | 600.000          |
| 3                 | Цайны зардал   | Нийт оролцогч 280, үйл ажиллагаа зохион байгуулах 2 өдөрт 4 удаа цай өгнө. Нэг удаагийн цайны үнэ 2500 | 2.240.000        |
| <b>Нийт дүн</b>   |  |  | <b>4.340.000</b> |
| <b>Бүх зардал</b> |  |  | <b>5.255.860</b> |